



АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



# ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГААНЫ ҮР ДҮН

ᠮᠣᠩᠭᠡᠯᠠᠯᠤᠯᠤᠰᠤ ᠤᠨᠳᠡᠰᠦᠨᠢ  
ᠰᠤᠲᠢᠰᠲᠢᠬᠤ ᠬᠡᠯᠲᠡᠰ  
- 2021

## ТАЙЛАН ХЯНАСАН:

Маширын Оюунцэцэг  
ҮСХ-ны ХАНСГ-ын ахлах статистикч

Бат-Өлзийн Адъяа  
Статистикийн хэлтсийн дарга

## ТАЙЛАН БИЧИЖ БОЛОВСРУУЛСАН:

Цэдэнсүрэнгийн Отгонцэцэг  
Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Болдбаатарын Өлзий-Утас  
Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

Балдангийн Батбаяр  
Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

Мөнхжаргалын Мөнхцэцэг  
Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

Ганболдын Туяачимэг  
Статистикийн хэлтсийн зохион байгуулагч

## АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ .....	4
ЗУРГИЙН ЖАГСААЛТ .....	4
ӨМНӨХ ҮГ .....	5
ҮНДСЭН ҮР ДҮН .....	6
ДҮГНЭЛТ .....	20
ХАВСРАЛТ 1. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, АНГИЛАЛ .....	21
ХАВСРАЛТ 2. АСУУЛГЫН ХУУДАС.....	25

## **ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

ХҮСНЭГТ 1. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчид, төрийн албаны ангиллаар, хүйсээр, дүнд эзлэх хувиар .....	7
ХҮСНЭГТ 2. Албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн эсэх, насны бүлэг, хүйсээр .....	8
ХҮСНЭГТ 3. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, хүйсээр, дүнд эзлэх хувиар .....	10
ХҮСНЭГТ 4. Үндэсний бичгийн мэдлэгтэй төрийн албан хаагчийн үндэсний бичгээр бичих чадвар, төрийн албан хаагчийн ангилал, албан тушаалын төрөл, боловсролын түвшингээр, хувиар.....	14
ХҮСНЭГТ 5. Үндэсний бичгийн мэдлэгтэй төрийн албан хаагчийн үндэсний бичгээр унших чадвар, насны бүлэг, хүйсээр, албан тушаалын төрлөөр, хувиар .....	16
ХҮСНЭГТ 6. Үндэсний бичгийн сургалт шаардлагатай эсэх, сургалт авахыг хүсэж буй албан хаагчийн сонирхож байгаа сургалтын хэлбэр, төрийн албаны ангиллаар, албан тушаалын төрлөөр, хувиар.....	18

## **ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

ЗУРАГ 1. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын тоо, сумдаар.....	6
ЗУРАГ 2. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагч, албан тушаалын төрлөөр, сумаар, дүнд эзлэх хувиар .....	7
ЗУРАГ 3. Албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн эсэх, албан тушаалын төрлөөр, хувиар.....	8
ЗУРАГ 4. Албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн эсэх, сумаар, дүнд эзлэх хувиар .....	9
ЗУРАГ 5. Үндэсний бичгийн мэдлэгийн түвшин, албан тушаалын төрлөөр, хувиар .....	11
ЗУРАГ 6. Үндэсний бичгийн мэдлэг, насны бүлэг, дүнд эзлэх хувиар .....	12
ЗУРАГ 7. Үндэсний бичгийн мэдлэг, сумдаар, дүнд эзлэх хувиар.....	12
ЗУРАГ 8. Үндэсний бичгийн мэдлэгтэй төрийн албан хаагчийн үндэсний бичгээр бичих чадвар, насны ангилал, дүнд эзлэх хувиар.....	14
ЗУРАГ 9. Өгөгдсөн эхийг унших чадвар, суралцсан жил, дүнд эзлэх хувиар .....	17
ЗУРАГ 10. Үндэсний бичгийн сургалтад хамрагдах хэрэгцээ шаардлага байгаа эсэх, төрийн албан хаагчийн насны бүлэг, хувиар .....	18
ЗУРАГ 11. Үндэсний бичгийн сургалтад хамрагдах хүсэлтэй албан хаагчид сумаар, сургалтын төрлөөр, хувиар .....	19



## ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Засгийн газраас 1995-2005 онд “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр I”, 2008-2015 онд “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр II”-ийг тус тус хэрэгжүүлсэн. “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр I, II” хэрэгжсэнээр ерөнхий боловсролын сургуулийн VI-IX ангид монгол бичиг хичээлийг судалж, иргэний болон боловсролын баримт бичгийг кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн үйлдэх, ном, сурах бичиг зохиох, хөрвүүлэх, түүх, соёлын бүтээлийг нийтийн хүртээл болгох зэрэг үр дүн бий болсон. Гэвч “Бүх нийтэд монгол бичгийг сургах, нийтийн хэрэглээний бичиг болгох, хэрэглэх орчин бий болгох” зэрэг зорилтууд хангалтгүй хэрэгжиж иржээ.

Иймд Монгол Улсын Их хурлаас 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдөр “Монгол хэлний тухай” хуулийг баталж, 2015 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан байдаг. Тус хуулийн 11 дүгээр зүйлд Монгол Улсын Засгийн газрын хүлээх үүргийг тодорхойлохдоо “монгол хэл, бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, хамгаалах, хөгжүүлэх, үндэсний бичгийн хэрэглээнд албан ёсоор шилжих дунд болон урт хугацааны үндэсний хөтөлбөр, дүрэм, журам, үндсэн чиглэл боловсруулж хэрэгжүүлэх” гэж, мөн хуулийн 7.2-т “Энэ хуулийн 11.1.2-т заасан үндэсний бичгийн хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна” гэж, 24.2-т “Энэ хуулийн 7.2 дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэж тус тус заасан нь энэхүү хөтөлбөрийг шинэчлэн батлуулах эрх зүйн үндэслэл болсон. Тус хуулийн хэрэгжилтийг хангахаар даган гарсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан.


“Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-ын зорилго нь 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжихэд монгол бичгийн сургалт, судалгаа, хэрэглээний орчныг бүрдүүлж, бэлтгэлийг бүрэн хангахад чиглэсэн.

Архангай аймгийн хэмжээнд “Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа”-г Үндэсний статистикийн хорооноос ирүүлсэн удирдамжийн дагуу 4 дүгээр сарын 15-наас 4 дүгээр сарын 30-ны хооронд зохион байгуулан явуулсан. Судалгаанд хамрагдах төрийн албан хаагчдын мэдээллийг “Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллого”-ын мэдээллийн сангаас гаргаж, хүн бүрт тусгай эрх, нууц үгийг олгон цахим асуулгаар мэдээлэл цуглууллаа. Судалгааг зохион байгуулахдаа төрийн албан хаагчид өөрийн байгаа газраасаа нэвтрэх нэр, нууц үг ашиглан цахимаар судалгаанд хамрагдсан нь цаашид энэ төрлийн судалгааг богино хугацаанд, өргөн хүрээнд хийх боломжтойг харуулсан нь онцлог болов.

Архангай аймгийн хэмжээнд нийт 5326 төрийн албан хаагч судалгаанд хамрагдсан бөгөөд судалгааны үндсэн үр дүнг та бүхэндээ хүргэж байна. Судалгааны үр дүнгийн энэ танилцуулга, аймгийн хэмжээнд үндэсний бичгийн боловсролыг дээшлүүлэх бодлого, хөтөлбөрийг боловсруулахад шаардлагатай мэдээлэл болно гэдэгт бид итгэлтэй байна. Судалгаанд идэвх зүтгэл гарган хамтран ажилласан сумдын Засаг даргын тамгын газрын дарга, статистик хариуцсан ажилтан, аймгийн хэлтэс, агентлаг, байгууллагын дарга, хүний нөөцийн ажилтан, судалгаанд хамрагдсан төрийн албан хаагч нарт талархал илэрхийлье

## ҮНДСЭН ҮР ДҮН

Архангай аймгийн хэмжээнд 5326 төрийн албан хаагч судалгаанд хамрагдсаны 1817 нь (34.1%) аймгийн төв буюу Эрдэнэбулган сумын төрийн албан хаагчид байна.



ЗУРАГ 1. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын тоо, сумдаар

Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 1717 буюу 32.2 хувь нь эрэгтэй, 3609 буюу 67.8 хувь нь эмэгтэйчүүд байна. Хүйсээр нарийвчилж харвал улс төрийн албан хаагчдын 31.2 хувь, захиргааны албан хаагчдын 54.6 хувь, тусгай албан хаагчдын 77.0 хувь, үйлчилгээний албан хаагчдын 72.6 хувь нь эмэгтэй ажилтнууд байна. Аймгийн төрийн үйлчилгээний болон төрийн тусгай албанд ажиллаж байгаа 3 ажилтан тутмын 2 нь эмэгтэй, харин улс төрийн албан хаагчдын 3 ажилтан тутмын 2 нь эрэгтэй, төрийн захиргааны албан хаагчдын хүйсийн харьцаа тэнцвэртэй байна.

Төрийн албан хаагчдыг насны бүлгээр ангилж авч үзвэл 34.4 хувь нь буюу 1833 ажилтан 15-34 настай, 43.3 хувь нь буюу 2304 ажилтан 35-49 настай, 20.8 хувь нь буюу 1109 ажилтан 50-59 настай, 1.5 хувь нь буюу 80 ажилтан 60-70 настай байна. Аймгийн нийт

төрийн албан хаагчдын 88.7 хувийг 25-54 насныхан үүн дотор 30-34 насныхан хамгийн их буюу 19.3 хувийг эзэлж байна.


Судалгаанд хамрагдагчдыг төрийн албан хаагчийн ангиллаар авч үзвэл 12.4 хувь нь буюу 659 ажилтан нь захиргааны, 6.4 хувь нь буюу 343 ажилтан нь улс төрийн, 1.9 хувь нь буюу 100 ажилтан нь тусгай албаны, 79.3 хувь нь буюу 4224 ажилтан нь үйлчилгээний албан хаагчид байна.

*ХҮСНЭГТ 1. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчид, төрийн албаны ангиллаар, хүйсээр, дүнд эзлэх хувиар*

Төрийн албаны ангилал	Төрийн албан хаагчдын тоо	Дүнд эзлэх хувь		
		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
<b>Бүгд</b>	<b>5326</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Төрийн улс төрийн алба	343	6.4	13.8	3.0
Төрийн захиргааны алба	659	12.4	17.4	10.0
Төрийн тусгай алба	100	1.9	1.3	2.1
Төрийн үйлчилгээний алба	4224	79.3	67.5	84.9

Судалгаанд хамрагдсан нийт төрийн албан хаагчдын 9.6 хувь нь удирдах албан тушаалд, 60.3 хувь нь гүйцэтгэх албан тушаалд, 30.1 хувь нь туслах албан тушаалд ажиллаж байна.

*ЗУРАГ 2. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагч, албан тушаалын төрлөөр, сумаар, дүнд эзлэх хувиар*




## ҮНДЭСНИЙ БИЧИГ ХЭРЭГЛЭХЭД БЭЛЭН ЭСЭХ

Судалгааны асуулгаар төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын албан хаагчид 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн байгаа эсэхийг асууж судалсан.

Архангай аймгийн хэмжээнд удирдах шатны албан хаагчдын 57.8, гүйцэтгэх шатны албан хаагчдын 55.9, туслах шатны албан хаагчдын 44.9 хувь нь албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн байна гэж хариулжээ.

*ЗУРАГ 3. Албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн эсэх, албан тушаалын төрлөөр, хувиар*



Судалгаанд хамрагдсан 30-34 насны албан хаагчдын 19.3 хувь, 35-39 насны албан хаагчдын 16.5 хувь нь албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн гэж хариулт өгсөн нь бусад насны бүлгийнхнээс өндөр байна.

*ХҮСНЭГТ 2. Албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн эсэх, насны бүлэг, хүйсээр*

	Бүгд			Тийм			Үгүй		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
15-19	0.2	0.3	0.1	0.1	0.4	0.1	0.2	0.3	0.1
20-24	2.7	2.4	2.9	3.2	2.7	3.3	2.3	2.2	2.4
25-29	12.2	10.9	12.8	13.1	13.0	13.2	11.2	9.1	12.3
30-34	19.3	19.2	19.3	19.6	21.7	18.6	19.0	16.8	20.2
35-39	16.5	15.4	17.0	19.3	18.8	19.5	13.4	12.3	14.0
40-44	13.0	10.9	14.0	13.8	11.1	14.9	12.1	10.7	12.9
45-49	13.8	11.5	14.9	13.0	9.5	14.5	14.6	13.3	15.3
50-54	14.0	14.6	13.7	11.1	10.5	11.4	17.1	18.2	16.5
55-59	6.8	11.9	4.5	5.8	10.2	3.8	8.2	13.4	5.3
60-64	1.2	2.5	0.5	0.7	1.6	0.3	1.6	3.4	0.8
65-69	0.2	0.3	0.2	0.2	0.4	0.2	0.2	0.2	0.1




70+	0.1	0.1	0.1	0.1	0.1	0.2	0.1	0.1	0.1
-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----

Энэ өндөр хувь Монгол Улс ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөртөө өөрчлөлт оруулж 1987 оноос эхлэн 7 дугаар ангийн сурагчдад монгол бичгийг зааж эхэлсэн мөн 1992-1994 онуудад 1 дүгээр ангид элсэн суралцагчдад монгол бичгээр хичээл зааж эхэлсэнтэй холбоотой байх магадлалтай.

Архангай аймгийн нийт төрийн албан хаагчдын 52.8 хувь нь албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн байна. Сумаар харвал Хангай, Өлзийт, Төвшрүүлэх, Хотонт сумдын төрийн албан хаагчдын 60.4-72.5 хувь нь бэлэн байгаа нь хамгийн өндөр, Чулуут, Тариат, Өгийнуур сумдын төрийн албан хаагчдын 40.4-46.0 хувь бэлэн байгаа нь хамгийн бага хувьтай байна.

**ЗУРАГ 4. Албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн эсэх, сумаар, дүнд эзлэх хувиар**



## ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГ


Судалгааны үр дүнгээр аймгийн төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийн түвшинг маш сайн, сайн, дунд зэрэг, бага зэрэг, мэдлэггүй гэж 5 ангилсан. Аймгийн хэмжээнд нийт төрийн албан хаагчдын 4.9 хувь нь үндэсний бичгээ маш сайн мэддэг, 12.8 хувь сайн, 27.3 хувь нь дунд, 25.8 хувь нь бага зэрэг мэддэг гэж хариулсан байна. Харин нийт албан хаагчдын 29.2 хувь буюу 1553 ажилтан үндэсний бичгээ огт мэддэггүй гэжээ. Эмэгтэй төрийн албан хаагчдын 6.2 хувь нь үндэсний бичгээ маш сайн мэддэг, 15.1 хувь нь сайн, 29.9 хувь нь дунд, 25.1 хувь нь бага зэрэг мэддэг, харин 23.6 хувь нь буюу 850 ажилтан үндэсний бичгээ огт мэддэггүй байна.

*ХҮСНЭГТ 3. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг, хүйсээр, дүнд эзлэх хувиар*


	Төрийн албаны ангилал				
	Бүгд	Төрийн улс төрийн алба	Төрийн захиргааны алба	Төрийн тусгай алба	Төрийн үйлчилгээний алба
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0
Маш сайн	4.9	3.2	4.7	9.0	5.0
Сайн	12.8	10.5	15.6	11.0	12.6
Дунд зэрэг	27.3	23.3	31.6	29.0	26.9
Бага зэрэг	25.8	24.2	30.6	27.0	25.2
Үгүй, мэдлэггүй	29.2	38.8	17.5	24.0	30.3
	Эрэгтэй				
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0
Маш сайн	2.2	2.1	3.3	-	2.0
Сайн	7.9	8.9	12.0	-	6.7
Дунд зэрэг	21.8	19.9	28.4	34.8	20.2
Бага зэрэг	27.2	22.9	32.9	34.8	26.5
Үгүй, мэдлэггүй	40.9	46.2	23.4	30.4	44.6
	Эмэгтэй				
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0
Маш сайн		5.6	5.8	11.7	6.1
Сайн	15.2	14.0	18.6	14.3	14.8
Дунд зэрэг	29.9	30.8	34.2	27.3	29.4
Бага зэрэг	25.1	27.2	28.9	24.6	24.8
Үгүй, мэдлэггүй	23.6	22.4	12.5	22.1	24.9

Үндэсний бичгийн мэдлэгийн түвшинг албан тушаалын төрлөөр авч үзвэл удирдах шатны албан тушаалтны 5.6 хувь, гүйцэтгэх шатны албан тушаалтны 6.4 хувь, туслах шатны албан тушаалтны 1.7 хувь нь маш сайн мэддэг гэсэн байна.

ЗУРАГ 5. Үндэсний бичгийн мэдлэгийн түвшин, албан тушаалын төрлөөр, хувиар




Архангай аймгийн төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийн түвшинг насны бүлгээр ангилж харахад 20-24, 35-44 насанд маш сайн мэддэг ажилтны хувийн жин 6.8-8.8 хувь, сайн мэддэг ажилтны хувийн жин 15-24, 35-44 насанд 18.6-22.2 хувь байгаа нь хамгийн өндөр байна. Үндэсний бичгээ дунд зэрэг мэддэг ажилтны хувийн жин 15-19, 25-39 насны бүлэгт 31.8-35.4 хувь буюу хамгийн өндөр байна. Харин 50-64 насны бүлгийн ажилтнуудын 52.5-58.1 хувь нь үндэсний бичгээ огт мэдэхгүй байна.



ЗУРАГ 6. Үндэсний бичгийн мэдлэг, насны бүлэг, дүнд эзлэх хувиар

Үндэсний бичгээ Эрдэнэмандал, Хайрхан, Хотонт, Жаргалант сумдын төрийн албан хаагчдын 6.4-7.4 хувь нь маш сайн, Хангай, Цахир, Төвшрүүлэх сумдын төрийн албан хаагчдын 16.3-19.1 хувь нь сайн мэдэж байна. Харин Тариат, Өлзийт сумдын төрийн албан хаагчдын 30.8-31.0 хувь нь бага зэрэг мэддэг, Өндөр-улаан, Хайрхан, Цэнхэр, Цэцэрлэг сумдын төрийн албан хаагчдын 38.4-46.4 хувь нь огт мэдэхгүй байна.

ЗУРАГ 7. Үндэсний бичгийн мэдлэг, сумдаар, дүнд эзлэх хувиар



## БИЧГИЙН ЧАДВАР

Судалгаагаар үндэсний бичгийн тодорхой түвшний мэдлэгтэй (70.8 хувь) гэж хариулсан албан хаагчдын унших чадварыг тодорхойлсноос гадна бичих чадварыг мөн асуусан. Үндэсний бичгийн талаар тодорхой түвшний мэдлэгтэй албан хаагчдын 12.8 хувь нь сайн бичиж чадна, 36.8 хувь нь дунд зэрэг, 40.2 хувь нь бага зэрэг, 10.3 хувь нь бичиж чадахгүй гэж хариулсан байна. Мөн төрийн үйлчилгээний албан хаагчдын 13.1 хувь,




удирдах албан тушаалтны 14.9 хувь, магистрын боловсролтой албан хаагчдын 24.4 хувь сайн бичиж чадна гэж хариулжээ.

*ХҮСНЭГТ 4. Үндэсний бичгийн мэдлэгтэй төрийн албан хаагчийн үндэсний бичгээр бичих чадвар, төрийн албан хаагчийн ангилал, албан тушаалын төрөл, боловсролын түвшингээр, хувиар*

Төрийн албан хаагчийн ангилал	Үндэсний бичгээр бичих чадвар			
	Тийм, сайн бичиж чадна	Тийм, дунд зэрэг бичиж чадна	Тийм, бага зэрэг бичиж чадна	Үгүй, бичиж чадахгүй
Бүгд	100.0	100.0	100.0	100.0
Төрийн улс төрийн алба	4.4	5.3	5.9	6.5
Төрийн захиргааны алба	13.7	14.7	14.1	15.8
Төрийн тусгай алба	1.7	1.9	2.4	1.6
Төрийн үйлчилгээний алба	80.2	78.1	77.6	76.1
Албан тушаалын төрлөөр				
Бүгд	100.0	100.0	100.0	100.0
Удирдах	12.7	11.8	9.8	9.6
Гүйцэтгэх	74.2	70.7	62.6	55.8
Туслах	13.1	17.5	27.6	34.6
Албан хаагчийн боловсролын түвшингээр				
Бүгд	100.0	100.0	100.0	100.0
Боловсролгүй	-	0.1	-	0.3
Бага	0.2	0.1	0.5	1.0
Суурь	0.2	1.1	4.4	6.7
Бүрэн дунд	3.9	6.8	12.3	14.2
Техник болон мэргэжлийн	0.4	2.3	5.5	7.5
Тусгай мэргэжлийн дунд	2.9	4.1	8.1	10.6
Дипломын дээд	3.1	5.9	8.0	6.5
Бакалавр	64.4	64.5	50.6	46.8
Магистр	24.5	13.9	9.9	5.9
Доктор	0.4	1.2	0.7	0.5

Судалгаанд хамрагдсан албан хаагчдын үндэсний бичгээр бичих чадварыг насны ангиллаар авч үзэхэд 35-39 насны албан хаагчдын 26.1 хувь нь бичих чадвар сайн гэж хариулсан байхад 50-54 насны албан хаагчдын 18.9 хувь нь бичиж чадахгүй гэж хариулжээ.

*ЗУРАГ 8. Үндэсний бичгийн мэдлэгтэй төрийн албан хаагчийн үндэсний бичгээр бичих чадвар, насны ангилал, дүнд эзлэх хувиар*



## УНШИХ ЧАДВАР

Судалгаанд хамрагдсан 35-39 насны албан хаагчдын 4 хүн тутмын нэг нь буюу 25.2 хувь нь өгөгдсөн эхийг бүтнээр нь унших чадвартай байна. Зарим эхийг унших чадвартай албан хаагч 20-34 насныханд 24.6 хувь, огт унших чадваргүй албан хаагч 30-34 насныханд 22.0 хувь байгаа нь хамгийн өндөр байна.

**ХҮСНЭГТ 5. Үндэсний бичгийн мэдлэгтэй төрийн албан хаагчийн үндэсний бичгээр унших чадвар, насны бүлэг, хүйсээр, албан тушаалын төрлөөр, хувиар**

Насны бүлэг	Үндэсний бичгээр унших чадвар		
	Огт уншиж чадаагүй	Зарим хэсгийг унших чадвартай	Бүтнээр нь унших чадвартай
Бүгд	100.0	100.0	100.0
15-19	-	0.1	0.2
20-24	2.1	3.1	3.5
25-29	16.1	15.7	11.2
30-34	22.0	24.6	17.9
35-39	13.1	15.8	25.2
40-44	7.4	11.3	19.6
45-49	13.1	12.8	14.0
50-54	19.9	10.3	5.5
55-59	5.7	4.9	2.7
60-64	0.6	1.2	0.2
65-69	-	0.2	-
70+	-	0.1	0.2
Хүйсээр			
Бүгд	100.0	100.0	100.0
Эрэгтэй	41.2	29.1	20.3
Эмэгтэй	58.8	70.9	79.7
Албан тушаалын төрлөөр			
Бүгд	100.0	100.0	100.0
Удирдах	10.4	9.3	13.3
Гүйцэтгэх	51.0	64.7	72.5
Туслах	38.6	26.0	14.2

Судалгаагаар үндэсний бичгийн тодорхой түвшний мэдлэгтэй гэж хариулсан албан хаагчдад дараах энгийн, богино өгүүлбэрийг уншуулж, бүтэн уншиж чадсан эсэх, үгүй бол хэдэн үг уншсан, уншаад ойлгосон


Ус бол амьдралын амин чухал эх булаг мөн. Хүн амьтны усны хэрэгцээ нэн их. Насанд хүрсэн хүний биеийн жингийн 65-70 хувийг ус эзлэх боловч эрхтэн бүрд адилгүй хэрэгцээтэй байдаг. Шүдний пааланд ус хамгийн багаар

Ус бол амьдралын амин чухал эх булаг мөн. Хүн амьтны усны хэрэгцээ нэн их. Насанд хүрсэн хүний биеийн жингийн 65-70 хувийг ус эзлэх боловч эрхтэн бүрд адилгүй хэрэгцээтэй байдаг. Шүдний пааланд ус хамгийн багаар

эсэхийг нь тодруулах байдлаар унших чадварыг тодорхойлсон.

Судалгаанд өгөгдсөн дээрх эхийг нийт хамрагдсан төрийн албан хаагчдын 37.3 хувь нь бүтнээр нь уншиж чадсан бол 53.7 хувь нь зарим хэсгийг уншиж чадсан, 8.9 хувь нь огт уншиж чадаагүй байна.

ЗУРАГ 9. Өгөгдсөн эхийг унших чадвар, суралцсан жил, дүнд эзлэх хувиар




## СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭ

Архангай аймгийн төрийн албан хаагчдад үндэсний бичгийн сургалтад хамрагдах хэрэгцээ шаардлага байгаа эсэх, ямар хэлбэрийн сургалтад хамрагдах хүсэлтэй зэргийг энэ судалгаагаар мөн асууж судалсан.

Судалгаанд хамрагдсан нийт төрийн албан хаагчдын 85.8 хувь нь үндэсний бичгийн сургалтад хамрагдах хүсэлтэй гэж хариулсан бол 14.2 хувь нь сургалтад хамрагдах шаардлага байхгүй гэж үзсэн байна. Насны бүлгээр задалж харвал 25-29, 30-34, 65-69 насныханд сургалтад хамрагдах сонирхол хамгийн их байна.

ЗУРАГ 10. Үндэсний бичгийн сургалтад хамрагдах хэрэгцээ шаардлага байгаа эсэх,



төрийн албан хаагчийн насны бүлэг, хувиар

Үндэсний бичгийн

Сургалт авахыг хүсч буй албан хаагчдын

Цаашид үндэсний бичгийнхээ мэдлэг чадварыг сайжруулах зорилгоор аймгийн нийт төрийн албан хаагчдын 65.1 хувь нь танхимын сургалт авах, 24.4 хувь нь цахим сургалт авах, 10.5 хувь нь бусад хэлбэрийн сургалт авах хүсэлтэй байна.


**ХҮСНЭГТ 6. Үндэсний бичгийн сургалт шаардлагатай эсэх, сургалт авахыг хүсэж буй албан хаагчийн сонирхож байгаа сургалтын хэлбэр, төрийн албаны ангиллаар, албан тушаалын төрлөөр, хувиар**



	сургалт шаардлагатай байгаа эсэх		сонгосон сургалтын хэлбэр		
	Тийм	Үгүй	Онлайн сургалт	Танхимын сургалт	Бусад хэлбэрийн сургалт
<b>Төрийн албаны ангилал</b>					
Бүгд	85.8	14.2	24.4	65.1	10.5
Төрийн улс төрийн алба	84.5	15.5	30.7	63.8	5.5
Төрийн захиргааны алба	91.5	8.5	24.7	62.5	12.8
Төрийн тусгай алба	83.0	17.0	42.2	51.8	6.0
Төрийн үйлчилгээний алба	85.1	14.9	23.4	66.0	10.6
<b>Албан тушаалын төрөл</b>					
Бүгд	85.8	14.2	24.4	65.1	10.5
Удирдах	88.3	11.7	30.5	59.3	10.2
Гүйцэтгэх	87.6	12.4	25.3	63.8	10.9
Туслах	81.6	18.4	20.3	70.0	9.7

Тариат, Өгийнуур, Хашаат, Төвшрүүлэх, Хайрхан сумдын төрийн албан хаагчдын 75.4-82.3 хувь нь танхимын сургалт авах хүсэлтэй байгаа бол, Өлзийт, Батцэнгэл, Булган, Жаргалант, Өндөр-улаан, Хангай, Хотонт, Цахир, Чулуут, Эрдэнэмандал, Эрдэнэбулган сумдын төрийн албан хаагчдын 20.4-38.9 хувь нь цахим сургалт авах хүсэлтэй байна. Иймд төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг дээшлүүлэхийн тулд танхимын болон цахим сургалт хослуулан явуулах нь илүү үр дүнтэй байж болох юм.

**ЗУРАГ 11. Үндэсний бичгийн сургалтад хамрагдах хүсэлтэй албан хаагчид сумаар, сургалтын төрлөөр, хувиар**



## ДУГНЭЛТ

Архангай аймгийн хэмжээнд 5326 төрийн албан хаагч судалгаанд хамрагдсаны 52.8 хувь нь цаашид албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн байна. Кирилл болон үндэсний бичгийг хослуулан хэрэглэхэд бэлэн эсэхийг насны бүлгээр харахад 15-19 насны ажилтны 44.4 хувь, 20-44 насны ажилтны 53.6- 61.8 хувь, 45-64 насны ажилтны 30.6-49.9 хувь, 65-69 насны ажилтны 63.6 хувь, 70-аас дээш насны ажилтны 57.1 хувь нь бэлэн байна.

Нийт төрийн албан хаагчдын 70.8 хувь нь үндэсний бичгийн тодорхой түвшний мэдлэгтэй, үүнээс 12.8 хувь нь сайн мэддэг, харин 29.2 хувь нь огт мэддэггүй байна. Үндэсний бичгийн тодорхой түвшний мэдлэгтэй төрийн албан хаагчдын 37.3 хувь нь энгийн өгүүлбэрийг бүрэн унших чадвартай, 53.7 хувь нь зарим хэсгийг нь унших чадвартай байгаа бол 8.9 хувь нь огт унших чадваргүй байна. Үндэсний бичгийн тодорхой түвшний мэдлэгтэй төрийн албан хаагчдын 12.8 хувь нь үндэсний бичгээр сайн бичдэг, 36.8 хувь нь дунд зэрэг, 40.2 хувь нь бага зэрэг бичиж чадна гэж хариулсан бол 10.3 хувь нь огт бичиж чадахгүй гэжээ.

Судалгаанд хамрагдсан 35-39 насны албан хаагчдын 4 хүн тутмын нэг нь буюу 25.2 хувь нь өгөгдсөн эхийг бүтнээр нь унших чадвартай байна. Зарим эхийг унших чадвартай албан хаагч 20-34 насныханд 24.6 хувь, огт унших чадваргүй албан хаагч 30-34 насныханд 22.0 хувь байгаа нь хамгийн өндөр байна.

Судалгаанд хамрагдсан нийт төрийн албан хаагчдын 85.8 хувь нь үндэсний бичгийн сургалтад хамрагдах хүсэлтэй гэж хариулсан бол 14.2 хувь нь сургалтад хамрагдах шаардлага байхгүй гэж үзсэн байна. Насны бүлгээр задалж харвал 25-29, 30-34, 65-69 насны албан хаагчид сургалтад хамрагдах сонирхол хамгийн их байна.

Цаашид үндэсний бичгийнхээ мэдлэг чадварыг сайжруулах зорилгоор аймгийн нийт төрийн албан хаагчдын 65.1 хувь нь танхимын сургалт авах, 24.4 хувь нь цахим сургалт авах, 10.5 хувь нь бусад хэлбэрийн сургалт авах хүсэлтэй байна.

Архангай аймгийн хэмжээнд эхний ээлжинд төрийн албан хаагчдад, дараагийн шатанд нийт сурагч, оюутнууд, нийт ард иргэдэд монгол бичгийн мэдлэгийг түгээх, сургах ажлыг эрчимжүүлэн тусгай хөтөлбөр боловсруулан нэлээд далайцтай ажил хийн соёлын үнэт өв болох үндэсний бичгээ эзэмшиж авч үлдэх санаачлага гарган ажиллах нь зүйтэй юм.

## ХАВСРАЛТ 1. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, АНГИЛАЛ

### Судалгаанд хэрэглэсэн зарим ойлголт, тодорхойлолт

Ойлголт	Тодорхойлолт
<b>ТӨРИЙН АЛБАН ХААГЧ</b>	
Төрийн албан хаагч	Төрийн албан тушаалыг эрхэлж, эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг хэлнэ.
Төрийн байгууллага, албан газар	“Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 1-д зааснаар “Төрийн байгууллага, албан газар” гэдэг нь төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийг хэлнэ.
Төрийн алба	Төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх, төрийн бодлого боловсруулах, төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай бусад үйлчилгээг нийтэд хүргэх үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг хэлнэ.
<b>БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ</b>	
Бичиг үсэг мэддэг	Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) өдөр тутмын амьдралын тухай хамгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаг, энэ чадвар нь тодорхой хугацаа өнгөрсөн ч хэвээр хадгалагдаж үлдсэн хүнийг Бичиг үсэг мэддэг гэж үзнэ.
Бичиг үсэг мэддэггүй	Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаггүй, түүнчлэн унших бичих чадвараа тодорхой хугацааны дараа алдсан хүнийг Бичиг үсэг мэддэггүй гэнэ.
<b>БОЛОВСРОЛ</b>	
Боловсролгүй	ЕБС-ийн 3 дугаар ангийг 1975-1996 онуудад, 4 дүгээр ангийг 1975 он хүртэл болон 1997-2004 онуудад, 5 дугаар ангийг 2005 оноос хойш төгсөөгүй бол Боловсролгүй хүн гэнэ. Мөн 2020 онд ЕБС-ийн 1-5 дугаар ангид сурч байгаа, сурч байгаад сургуулиа орхисон хүмүүсийг Боловсролгүй гэж үзнэ.
Бага боловсрол	ЕБС-ийн 3 дугаар ангийг 1975-1996 онуудад, 4 дүгээр ангийг 1975 он хүртэл болон 1997-2004 онуудад, 5 дугаар ангийг 2005 оноос хойш төгссөн, мөн албан

бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн хүн.	
Бүрэн бус дунд (суурь) боловсрол	ЕБС-ийн 7 дугаар ангийг 1975 он хүртэл, 8 дугаар ангийг 1975-2004 онуудад, 9 дүгээр ангийг 2005 оноос хойш өдөр, орой эчнээгээр төгссөн, суурь боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн, суурь боловсролын гэрчилгээтэй хүн.
Бүрэн дунд боловсрол	ЕБС-ийн 10 дугаар ангийг 2005 он хүртэл, 11 дүгээр ангийг 2006-2014 онуудад, 12 дугаар ангийг 2015 оноос хойш өдөр, орой эчнээгээр төгссөн, мөн албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн, бүрэн дунд боловсролын аттестат ба үнэмлэхтэй хүн.
Техникийн болон мэргэжлийн боловсрол	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (хуучнаар техник, мэргэжлийн сургууль-ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүн.
Тусгай мэргэжлийн дунд боловсрол	Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүн.
Дээд боловсрол	Гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг Дээд боловсролтой гэж үзнэ. Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120, магистрын сургалт 150, докторын сургалт 210 багц цагаас тус тус доошгүй байна. Түүнчлэн Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизм оройн дээд сургууль Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүмүүсийг дипломын дээд боловсролтой гэж үзнэ.

## Судалгаанд хэрэглэсэн зарим ангилал

**Төрийн улс төрийн албан тушаалд** Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон болзол, журам, шалгуурын дагуу сонгогддог болон уг сонгуулийн үр дүнд томилолтын журмаар ажиллах, мөн тэдгээрийн бүрэн эрхийн хугацаанд өөрт нь үйлчлэх орон тооны дараах албан тушаал хамаарна.

Үүнд:

- Монгол Улсын Ерөнхийлөгч;
- Монгол Улсын Их Хурлын дарга;
- Монгол Улсын Ерөнхий сайд;
- Монгол Улсын Их Хурлын дэд дарга, гишүүн;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, дэд сайд;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх, Монгол Улсын Их Хурлын даргын зөвлөх, Ерөнхий сайдын зөвлөх;
- Бүх шатны Засаг дарга болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын орлогч;
- Улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийн хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх, туслах, хэвлэл мэдээллийн ажилтны албан тушаал;

- Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны албан тушаал;
- Хуульд заасан бусад албан тушаал.

Мөн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, хот, тосгоны захирагчийн албан тушаалыг төрийн улс төрийн албан тушаалтай адилтган үзэж болно. Улс төрийн албан хаагчийн бүрэн эрхийн хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх, туслах, хэвлэл мэдээллийн ажилтан нь тухайн албан тушаалтанд шууд захирагдах боловч төрийн албан хаагчийн хувьд тухайн байгууллагад харьяалагдана.

**Төрийн захиргааны албан тушаалд** Төрийн бодлого боловсруулахад мэргэшлийн зөвлөгөө өгөх, уг бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах, зохион байгуулах чиг үүрэг бүхий дараах албан тушаал хамаарна. Үүнд:

- Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүн, ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал;
- Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Үндсэн хуулийн цэцийн ажлын алба, шүүхийн захиргаа, прокурорын ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал;
- Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороо, Сонгуулийн ерөнхий хороо, Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал;
- Яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны удирдах, гүйцэтгэх албан тушаал;
- Хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газрын агентлагийн удирдах, гүйцэтгэх албан тушаал;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал;
- Хуульд өөрөөр заагаагүй бол аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх улсын төсвөөс санхүүждэг нутгийн захиргааны байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаал;
- Хот, тосгоны захирагчийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал;
- Хуульд заасан бусад албан тушаал.

**Төрийн тусгай албан тушаалд** Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам болон хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулахтай холбогдсон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх дараах албан тушаал хамаарна. Үүнд:

- Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга;
- Монгол банкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд, Дэд ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны гишүүн, Үндэсний статистикийн хорооны дарга, дэд дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүн, Үндэсний болон орон нутгийн аудитын газар, Авлигатай тэмцэх газрын удирдах, гүйцэтгэх албан тушаал;
- Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлага;
- Дипломат албан тушаал;



- Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын офицер, ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гаалийн байцаагч, шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтэн;
- Хуульд заасан бусад албан тушаал.

**Төрийн үйлчилгээний албан тушаалд** Төрийн үйлчилгээг адил тэгш, чанартай, хүртээмжтэй хүргэх болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах чиг үүрэг бүхий хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллах дараах албан тушаал хамаарна. Үүнд:

- Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаал;
- Боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, урлаг, спорт зэрэг төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын дарга, захирал, эрхлэгч, бусад удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаал;
- Яам, агентлагийн харьяа болон түүний дэргэд ажилладаг, төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаал.

## ХАВСРАЛТ 2. АСУУЛГЫН ХУУДАС

Үндэсний статистикийн хорооны даргын 20... оны ... дугаар сарын ...-ний өдрийн .../... дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлав.

Маягт - МБ



### ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГИЙГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА-2021

ХАЯГИЙН ХЭСЭГ		МВМ
МВМ1. Байгууллагын нэр		
МВМ2. Аймаг, нийслэлийн нэр, код	<input type="text"/>	МВМ6. Судалгаанд хамрагдсан огноо
МВМ3. Сүм, дүүргийн нэр, код	<input type="text"/>	2 0 2 1 / <input type="text"/> / <input type="text"/>
МВМ4. Төрийн албан хаагчийн овог, нэр		
МВМ5. Төрийн албан хаагчийн регистрийн дугаар	<input type="text"/>	

### ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

МВВ

Танаас авсан бүх мэдээллийн нууцыг Монгол Улсын "Хувь хүний нууцын тухай" хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг болон "Статистикийн тухай" хуулийн 22 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу чандлан хадгалах бөгөөд ямар нэгэн нэргүйгээр зөвхөн судалгааны үр дүнг тооцоход ашиглана. Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн зөвхөн төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлж, цаашид үндэсний бичгийг төрийн албан ёсны үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд хэрэгцээтэй үе шаттай сургалтын төлөвлөгөө боловсруулах юм. Иймд судалгаанд үнэн зөв хариулахыг **ТАНААС** хичээнгүйлэн хүсэж байна.

№	Асуулт	Хариулт	Алхам
МВВ1	Таны хүйс	Эрэгтэй ..... 1 Эмэгтэй ..... 2	
МВВ2	Та хэдэн настай вэ?	Бүтэн насыг бичнэ <input type="text"/>	
МВВ3	Та эзэмшсэн боловсролынхоо дээд түвшнийг хэлнэ үү? <i>Одоо сурч байгаа бол төгссөн түвшнийг сонгоно. Жишээ нь: Одоо их, дээд сургуульд магистрын зэрэг хамгаалахаар сурч байгаа төгсөөгүй, харин бакалаврын зэрэг хамгаалж, төгссөн бол "8"-ыг сонгоно.</i>	Боловсролгүй ..... 1 Бага ..... 2 Суурь (8/9-р анги төгссөн) ..... 3 Бүрэн дунд (10/12-р анги төгссөн) ..... 4 Техникийн болон мэргэжлийн /МСҮТ/ ..... 5 Тусгай мэргэжлийн дунд ..... 6 Дипломын дээд ..... 7 Бакалавр ..... 8 Магистр ..... 9 Доктор ..... 10	
МВВ4	Таны ажил эрхэлдэг байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл юу вэ?	<input type="text"/>	
МВВ5	Та ямар ажил эрхэлдэг вэ?	<input type="text"/>	
МВВ6	Таны эрхэлдэг ажил төрийн албаны аль ангилалд хамаардаг вэ?	Төрийн улс төрийн алба ..... 1 → МВВ8 Төрийн захиргааны алба ..... 2 Төрийн тусгай алба ..... 3 → МВВ8 Төрийн үйлчилгээний алба ..... 4 → МВВ8	
МВВ7	Та төрийн захиргааны албан тушаалын аль ангилалд хамаардаг вэ?	Тэргүүн түшмэл ..... 1 Эрхэлсэн түшмэл ..... 2 Ахлах түшмэл ..... 3 Дэс түшмэл ..... 4 Туслах түшмэл ..... 5	
МВВ8	Таны эрхэлдэг ажил төрийн албан тушаалын аль төрөлд хамаардаг вэ?	Удирдах ..... 1 Гүйцэтгэх ..... 2 Туслах ..... 3	
МВВ9	2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагад албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд Та бэлэн үү?	Тийм ..... 1 Үгүй ..... 2	

Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаа - 2021			Хуудас 2
№	Асуулт	Хариулт	Алхам
МВВ10	Танд цаашид үндэсний бичгийн сургалтад хамрагдах хэрэгцээ шаардлага байна уу?	Тийм ..... 1 Үгүй ..... 2	→ МВК1
МВВ11	Та ямар хэлбэрийн сургалтад хамрагдахыг хүсэж байна вэ? <i>Олон хариултын сонголттой.</i>	Онлайн сургалт ..... А Танхимын сургалт ..... В Бусад ..... Х	
<b>ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГ</b>			<b>МВК</b>
МВК1	Та үндэсний бичиг /монгол бичиг/ мэддэг үү? <i>Мэдлэг маш сайтай</i> гэдэгт үндэсний бичгээр чөлөөтэй уншдаг, бичдэг, тоо мэддэг хүнийг ойлгоно. <i>Мэдлэг сайн</i> гэдэгт үндэсний бичгээр уншдаг боловч бичих эсвэл тоо мэдэх чадвар багатай хүнийг ойлгоно. <i>Мэдлэг дунд зэрэг</i> гэдэгт үсгээ бүгдийг мэддэг, зарим үгийг уншиж чадах хэдий ч хүндэвтэр үгийг уншиж чадахгүй хүнийг ойлгоно. <i>Мэдлэг бага зэрэг</i> гэдэгт үндэсний бичгийн зөвхөн үсгээ мэддэг, унших болон бичих, тоо мэдэх чадвар байхгүй хүнийг ойлгоно. <i>Мэдлэггүй</i> гэдэгт үндэсний бичгийн үсгээ, тоо мэдэхгүй ялгахгүй, уншихгүй, бичихгүй буюу ямар нэвэр мэдлэг оет байхгүй хүнийг ойлгоно.	Тийм Маш сайн ..... 1 Сайн ..... 2 Дунд зэрэг ..... 3 Бага зэрэг ..... 4 Үгүй, мэдлэггүй ..... 5	→ Дуусгах
МВК2	Та үндэсний бичгийг дунджаар хэр хугацаанд үзсэн бэ? <i>9 сар үзсэн бол сар гэдгийн нүдэнд "09" гэж бичнэ. Нэг бүтэн хичээлийн жилийг нэг жил гэж үзнэ.</i>	Сар ..... <input type="text"/> <input type="text"/> Жил ..... <input type="text"/> <input type="text"/>	
МВК3	Та дараах эхийг уншина уу?	Огт уншиж чадаагүй ..... 1 Зарим хэсгийг унших чадвартай ..... 2 Бүтнээр нь унших чадвартай ..... 3	→ МВК6 → МВК5
МВК4	Та өгөгдсөн эхээс уншиж, утгыг ойлгосон үгийн тоог тоолж бичнэ үү? <i>Хэрэв, 8 үг уншсан бол нүдэнд "08" гэж бичнэ.</i>	Уншсан үгийн тоо ..... <input type="text"/> <input type="text"/>	
МВК5	Танаас уншсан эхтэй холбоотой асуулт асууя. А) Ус хэдэн хувийг эзэлнэ гэсэн бэ? Б) Хүний биений аль эрхтэнд ус бага хэрэглэгддэг вэ?	55-60 ..... 1 45-50 ..... 2 65-70 ..... 3 Хэл ..... 1 Шүдний паалан ..... 2 Элэг ..... 3	
МВК6	Та үндэсний бичгээр бичиж чаддаг уу?	Тийм Сайн бичиж чадна ..... 1 Дунд зэрэг бичиж чадна ..... 2 Бага зэрэг бичиж чадна ..... 3 Үгүй, бичиж чадахгүй ..... 4	
<i>Судалгаанд хамрагдсан танд баярлалаа</i>			
<i>Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчийн тэмдэглэл</i>			